



**ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАР**

**2023 оны 11 дүгээр сар**

**АУДИТЫН СЭДЭВ: ОРХОН АЙМГИЙН 2024  
ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН  
АУДИТЫН ДҮГНӨЛТ**



**ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2023 оны 11 сарын 27 өдөр

Дугаар А/15

Эрдэнэт

Аудитын тайланг баталгаажуулах  
тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, 20.3, 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар баталсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх”-ийн 1.1, 1.4 дэх хэсэг, “Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам”-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орхон аймгийн 2024 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх” аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргад хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (Д.Мөнхбат), аймгийн Засаг дарга (С.Батжаргал) нарт даалгасугай.
4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Б.Буян-Ундрах)-т даалгасугай.
5. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын баримт материалыг архивын нэгж болгон, архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (Т.Болормаа, В.Жавзмаа, Г.Оргилмөрөн)-т үүрэг болгосугай.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

**АГУУЛГА**

<b>Товчилсон үгийн тайлбар .....</b>	<b>3</b>
<b>Ерөнхий мэдээлэл .....</b>	<b>4</b>
<b>НЭГ. ОРХОН АЙМГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ НЬ УРТ БОЛОН ДУНД, БОГИНО ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛД НИЙЦСЭН БОЛОВЧ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.....</b>	<b>6</b>
Орхон аймгийн 2024 оны төсвийн төсөл нь Монгол Улсын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаатай 88.8%, дунд хугацааны хөгжлийн бодлого буюу аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлтэй 93.8%, богино хугацааны хөгжлийн бодлого болох аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөтэй 87% тус тус нийцэж байна. ....	6
Төсвийн төсөлд иргэдийн саналыг бүрэн тусгаагүй нь иргэд олон нийтийн оролцоо, ил тод байдлыг хангаагүй байна.....	9
<b>ХОЁР. СУМДЫН ОРЛОГЫГ БОДИТ ГҮЙЦЭТГЭЛД ҮНДЭСЛЭН НЭМЭГДҮҮЛЭХ, ЗАРДЛЫГ ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД НИЙЦҮҮЛЭН ХЭМНЭХ БОЛОМЖ БАЙНА. 10</b>	
Төсвийн орлогыг тооцоо судалгаанд тулгуурлаж бодитой төлөвлөснөөр төсвийн орлого 309.0 сая төгрөгөөр нэмэгдэх боломжтой байна. ....	10
Төсвийн зарлагыг 3,463.9 сая төгрөгөөр бууруулах боломжтой хэдий ч тооцоолол, судалгаагүй төлөвлөсөн байна. ....	13
<b>ГУРАВ. ТӨСВИЙН ТӨСӨЛД ШИНЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН ТАХ-НИЙ ЭДИЙН ЗАСГИЙН ҮР АШИГ, НИЙГМИЙН АЧ ХОЛБОГДЛЫН БОЛОН АШИГЛАЛТЫН ЗАРДЛЫН ТООЦООЛЛЫГ ХИЙХГҮЙ ТӨЛӨВЛӨСӨӨР БАЙНА.....</b>	<b>15</b>
Төсвийн төсөлд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний барилга байгууламжийн ангилалд төсөвлөлтийн шаардлага хангаагүй 11 төсөл, арга хэмжээг тусгасан байна. ....	15
Төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-г эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, урсгал зардлын тооцоолол, судалгаагүй төлөвлөж байна. ....	17
<b>ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ 75.0 ХУВЬТАЙ БАЙНА. ....</b>	<b>18</b>
<b>ДҮГНЭЛТ:.....</b>	<b>19</b>
<b>ЗӨВЛӨМЖ:.....</b>	<b>19</b>
<b>ХАВСРАЛТ:.....</b>	<b>20</b>

**Товчилсон үгийн тайлбар**

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ДТС	Дулаан түгээх сүлжээ
ОНӨХК	Орон нутгийн өмчит хувьцаат компани
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УЦУОШТ	Ус, цаг уур, орчны шинжилгээний төв
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ХБГ	Хүлээгдэж буй гүйцэтгэл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
БОЭТ	Бүсийн оношилгоо, эмчилгээний төв
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар

**АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ****Аудит хийх үндэслэл, бүрэн эрх**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1 дэх заалт, УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2022 оны “Аудитын сэдэв батлах тухай” 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны “Төрийн аудитын байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай” А/03 дугаар тушаалын дагуу Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд аудитыг гүйцэтгэлээ.

**Аудитын зорилт**

Орхон аймгийн Засаг даргаас аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн Орхон аймгийн 2024 оны төсвийн төслийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр боловсруулж, орон нутгийн эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, холбогдох шалгуур үзүүлэлтүүдэд нийцсэн эсэхэд дүгнэлт гаргахад аудитын зорилго оршино.

Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Төсвийн төсөл нь тогтвортой хөгжлийн бодлогод нийцсэн, Төсвийн тухай хууль тогтоомжид заасан шалгуурыг хангасан эсэх;
- Орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах нөөц боломж байгаа эсэх;
- Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг арвилан хэмнэлттэй байдлаар, санхүүжилтийн үр ашгийг харгалзан, оновчтой төлөвлөсөн эсэх;

**Аудитын хамарсан хүрээ**

Аудитыг Монгол Улсын нэгдсэн төсөв, Орхон аймгийн 2022, 2023 оны батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл /батлагдсан болон урьдчилсан/, 2024 оны төсвийн төсөл, танилцуулга, төсвийн орлого бүрдүүлдэг байгууллагуудаас ирүүлсэн судалгаа болон холбогдох бусад баримт материалд үндэслэн гүйцэтгэв.

Аудитад Орхон аймгийн Засаг даргын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хүрээнд цуглуулсан төсөвт байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлт зэргийг ашиглав.

**Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Төрийн аудит MNS 6817:2020 Монгол Улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, аудитыг чиглүүлж гаргасан бусад заавар, аргачлал, гарын авлагыг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, арга зүйн дагуу аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг зохих журмын дагуу цуглуулж, ажлын баримт материалд хавсаргасан болно.

Аудитад төсөв боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, журам, заавар аргачлалд заасан шаардлагыг гол шалгуур болголоо.

**Аудитын бүрэлдэхүүн, хугацаа**

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах хянан удирдаж, аудитын менежер Б.Буян-Ундрах үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор В.Жавзмаа, Г.Оргилмөрөн, Т.Болормаа, аудитор Б.Бямбатогтох, Ж.Наранчимэг, О.Гантуяа, Ц.Даваасүрэн, Ц.Одгэрэл нар 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн 2023 оны 11 дүгээр сарын 25-ний өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэв.

**Аудитын явцад учирсан хүндрэл, бэрхшээлүүд:**

Эцэслэсэн боловсруулсан төсвийн төслийг хүлээн авснаас хойш 6 хоногт гүйцэтгэсэн болон аудитад ирүүлсэн төсвийн төсөл иж бүрэн бус байсан зэрэг нь аудитын цар хүрээг хязгаарлах нөхцөл болж байна.

**Ерөнхий мэдээлэл**

Монгол Улсын Засгийн газар Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх, төлбөрийн тэнцлийн алдагдлыг бууруулах, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, үнийн өсөлтийг хязгаарлаж иргэдийн бодит орлогыг хамгаалах, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн бодлого, арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсвийн үзэл баримтлалд инфляцын түвшнийг 2024 оны эцэст 8.5 хувь, уул уурхай, түүнээс хамааралтай тээврийн салбарын өсөлтийн нөлөөгөөр эдийн засгийн өсөлтийг 7.0 хувьд хүргэхээр тооцож, гадаад эрсдэлийн нөлөө намжиж, эдийн засаг цар тахлын өмнөх түвшинд хүрч сэргэснээр “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг бүрэн утгаар нь хэрэгжүүлэх боломж бүрдэнэ гэж үзэж дараах төсвийн бодлогуудыг хэрэгжүүлэх шаардлагатайг дурдсан байна. Үүнд:

1. Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх 6 зорилтын нэг болох “Хот, хөдөөгийн сэргэлт”-ийг хэрэгжүүлэхэд онцгой анхаарсан төсвийн бодлого

баримтална. Энэхүү бодлогын хүрээнд хөгжил дагасан бүтээн байгуулалтыг хийх, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, эдийн засгаа тэлэхэд чиглэсэн төвийн арга хэмжээнүүдийг төлөвлөх,

2. Экспортыг нэмэгдүүлэх чиглэлд хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн ил тод арилжааг дэмжих, иргэдийн орлогыг хамгаалах чиглэлд цалин, тэтгэвэр тэтгэмжийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлж, хөгжилд суурилсан хөрөнгө оруулалтыг эрчимжүүлэх төсвийн бодлогыг хэрэгжүүлэх.

Улаанбаатар хотоос орон нутаг болон Багануур, Багахангай дүүргүүдэд шилжин суурьшиж, анх удаа орон сууц худалдан авахаар хүсэлтээ гаргасан иргэдэд ипотекийн зээлийн хүүгийн 3 нэгж хувийг эхний 3 жилд төсвөөс санхүүжүүлж, орон сууцны зээлийн урьдчилгаа төлбөрийн 60 хүүртэй хурьд баталгаа гаргах бодлогоор арга хэмжээг эрчимжүүлэх, орон нутагт амьдрах иргэдийн тав тухтай орчныг бүрдүүлэх, орон сууцны хамрагдалтыг улам нэмэгдүүлэх чиглэлээр 2024 оны төсвийн жилд Орхон аймагт авч хэрэгжүүлэх дараах арга хэмжээнүүд байна. Үүнд:

Орхон аймгийн Баян-Өндөр сумын хилийн цэс дотор шинээр барьсан нийтийн зориулалттай орон сууц борлуулсны орлогод ногдох албан татварыг 2024-2026 онд 50 хувиар, 2027-2029 онд 20 хувиар, бусад хилийн цэсийн дотор 2024-2026 онд 90 хувиар, 2027-2029 онд 50 хувиар тус тус хөнгөлнө.

Түүнчлэн орон нутагт түрээсийн орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нийтийн орон сууцны зориулалттай барилгал хүн амьдрал суух зориулалтаар орон сууц түрээслүүлсний орлогод ногдох хувь хүний болон ААНОАТ-г 2024-2026 онд 90 хувь, 2027-2029 онд 50 хувиар хөнгөлөлт үзүүлэхээр төлөвлөсөн байна.

Ирэх 2024 онд хөдөөгийн суманд ажиллаж байгаа төрийн захиргаа, төрийн үйлчилгээ, улс төрийн албан хаагчдад сар бүр үндсэн цалингийн 40 хувиар, харин аймгийн төвийн сум болон нийслэлийн алслагдсан гурван дүүрэгт ажиллаж байгаа төрийн албан хаагчдад сар бүр үндсэн цалингийн 20 хувиар тус тус тооцож орон нутгийн нэмэгдэл олгохоор төлөвлөсөн байна. Уг нэмэгдэлд төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчид болон улс төрийн албан хаагчид шинээр хамрагдах бөгөөд энэхүү нэмэгдлийг олгохтой холбогдуулан Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулжээ.

Мөн 2024 оноос орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд 1 удаа 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг олгохоор төлөвлөсөн байна.

Төрийн албан хаагчдын цалин хөлсийг үнийн өсөлттэй уялдуулан 2024 оны 4 дүгээр сараас эхлэн нийтлэг үйлчилгээ болон тохижилт үйлчилгээний салбарын ажилчдын цалинг 20 хувь, бусад төрийн албан хаагчдын цалинг 10 хувь нэмэгдүүлэхээр төсөвт тусгажээ.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.9 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2, 57.3 дахь хэсэг, 61 дүгээр зүйлийн 61.4 дэх хэсэг, 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн “Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал батлах тухай” 445 дугаар тогтоол, Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”, Сангийн яамны Төсвийн Ерөнхийлөн захирагч нарын 2024 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамж, чиглэлийг үндэслэн аймгийн 2024 оны төсвийн төслийг боловсруулсан байна.

**НЭГ. ОРХОН АЙМГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ НЬ УРТ БОЛОН ДУНД, БОГИНО ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛД НИИЦСЭН БОЛОВЧ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.**

Орхон аймгийн 2024 оны төсвийн төсөл нь Монгол Улсын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаатай 97.6%, дунд хугацааны хөгжлийн бодлого буюу аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлтэй 94.5%, богино хугацааны хөгжлийн бодлого болох аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөтэй 92.4% тус тус нийцэж байна.

1.1. Орхон аймгийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг 390,941.0 сая төгрөгөөр төлөвлөсний 46% буюу 179,620.9 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх шилжүүлэг, 9.4% буюу 36,904.1 сая төгрөгийг төрийн байгууллагын урсгал санхүүжилт, хөрөнгө оруулалтын арга хэмжээнд нийт 33.6% буюу 131,173.3 сая төгрөг, сумдын ОНХС-д 5.3% буюу 20,682.5 сая төгрөгийг тус тус зарцуулахаар төлөвлөжээ.

Хүснэгт 1. Төсвийн зарлага. /сая.төгрөг/

№	Зардлын ангилал	Мөнгөн дүн	Эзлэх хувийн жин
1	Орон нутгийн төрийн байгууллагын санхүүжилт	36,904.10	9.44 %
2	Жаргалант суманд олгох санхүүгийн дэмжлэг	6,975.30	1.78 %
3	Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ	62,222.80	15.92 %
4	Аймгийн ОНХС	68,950.50	17.64 %
5	Авто замын сан	1,962.00	0.50 %
6	Байгаль хамгаалах төсөл арга хэмжээ	2,729.60	0.70 %
7	Баян-Өндөр сум ОНХС	10,780.90	2.76 %
8	Жаргалант сум ОНХС	9,901.60	2.53 %
9	Төрийн болон орон нутгийн өмчийн барилгын ашиглалт зардал	7,936.50	2.03 %
10	Улсын төсөвт төвлөрүүлэх	179,620.90	45.95 %
11	Дамжуулан зээлийн эргэн төлөлт	2,956.80	0.76 %
	<b>Нийт мөнгөн дүн</b>	<b>390,941.00</b>	

1.2. Харин орон нутгийн өмчийн байрнуудын ашиглалтын зардал 2% буюу 7,936.5 сая төгрөг, авто замын сан болон байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээнүүд хамгийн бага 1.2% буюу 4,691.6 сая төгрөгийг эзэлж байна.

1.3. Төсвийн төсөлд 139,861.8 сая төгрөгийн 390 төсөл арга хэмжээг байгаль хамгаалах сан, төсөл хөтөлбөр, авто замын сан, Эрдэнэт сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр гүйцэтгэхээр тусгасан байна.

Хүснэгт 2. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төрөл. /сая.төгрөг/

№	Төсөл арга хэмжээний төрөл	ТАХ тоо	Мөнгөн дүн	
1	Барилга байгууламж	23	16,041.1	
2	шилжих хөрөнгө	Их засвар	7	224.3
3	оруулалт	Зөвлөх үйлчилгээ	7	800.9
4		Тоног төхөөрөмж	3	2,055.0
5	Шинэ хөрөнгө	Барилга байгууламж	75	24,963.5
6	оруулалт	Тоног төхөөрөмж	36	6,470.5
7	Төсөл хөтөлбөр		185	11,667.4
8		Шилжих х.о	2	2,484.6
9	Байгаль	Шинээр эхлэх х.о	2	240.0
10	хамгаалах сан	төсөл хөтөлбөр	1	5.0
11		Барилга байгууламж	2	672.0
12	Авто замын сан	Тоног төхөөрөмж	1	46.5
13		төсөл хөтөлбөр	3	1,243.5
14		Шилжих х.о	13	3,523.5
15	Аймгийн ОНХС	Шинээр эхлэх х.о	17	65,427.1

16	Эрдэнэт сан	шилжих үлдэгдэл	4	541.7
17		Шинэ хөрөнгө оруулалт	9	3,455.2
<b>Нийт мөнгөн дүн</b>			<b>390</b>	<b>139,861.8</b>

1.4. Дээрх 139,861.8 сая төгрөгийн 390 төсөл арга хэмжээнээс 11,667.4 сая төгрөгийн 185 төсөл арга хэмжээ нь урсгал үйл ажиллагааны шинж чанартай төсөл хөтөлбөрийн зардал байна.

1.5. Төсвийн төсөлд тусгагдсан 128,194.4 сая төгрөгийн 205 төсөл арга хэмжээг Алсын хараа-2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 8 чиглэлээр 42 зорилттой тулган баталгаажуулалт хийлээ.

*Хүснэгт 3. 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тусгагдсан байдал./сая.төгрөг/*

№	Зорилт	TAX тоо	Эзлэх хувь	Мөнгөн дүн
1	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	11	1.25 %	1,604.1
2	Хүний хөгжил	93	65.26 %	83,658.2
3	Амьдралын чанар ба дундаж давхарга	17	9.39 %	12,038.7
4	Эдийн засаг	39	9.19 %	11,786.9
5	Засаглал	4	4.26 %	5,463.3
6	Ногоон хөгжил	7	0.56 %	714.4
7	Амар тайван аюулгүй байдал	13	7.64 %	9,790.1
8	Бүс орон нутгийн хөгжил	1	0.05 %	61.0
9	Тусгагдаагүй бусад	20	2.4 %	3,077.8
<b>Нийт дүн</b>		<b>205</b>	<b>100.00</b>	<b>128,194.4</b>

1.6. Алсын хараа-2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 8 чиглэлийн 42 зорилтод тусгагдаагүй 3,077.8 сая төгрөгийн 20 төсөл арга хэмжээ нь 2.4%-ийг эзэлж байна. Тухайлбал:

- Эрдэнэт Ус ДТС ОНӨХК-ийн Захиргааны байр барих 605.1 сая төгрөг
- Хүнс хөдөө аж ахуйн агропарк сургалтын байр хашаа буулгах 67.6 сая төгрөг
- ХХҮГ-ын оффисын байрны дээврийн засварын ажил 30.1 сая төгрөг
- ХХҮГ-ын дэргэдэх Ахмадын сувиллыг "Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний сэргээн засалтын төв" болгон өргөжүүлэхтэй холбогдуулан их засвар хийх 220.9 сая төгрөг
- Эрчим хүчний хэмнэлттэй Хайбрид амины орон сууц барих 54.9 сая төгрөг
- Нутгийн удирдлагын ордны 3 дугаар давхрын өрөөг хүндэтгэлийн танхим болгон засварлаж тохижуулах 166.9 сая төгрөг
- Малчин баг. Худаг барих /Цохионы өвөрт/ 62.0 сая төгрөг
- Захиргааны 1 дүгээр байрны ариун цэврийн өрөөнүүдийн засвар хийх 116.0 сая төгрөг
- Согоот баг. Баян-Өндөр сумын 14-р сургуулийн дутуу баригдсан өргөтгөлийг буулгах 300.0 сая төгрөг
- Аймгийн ёслолын өргөөнд засвар хийх 100.0 сая төгрөг
- ОНӨГ-ын ажлын байрны засвар, тохижилт хийх /Зэст багийн байранд орох/ 61.7 сая төгрөг
- Худалдан авах ажиллагааны газарт шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах 60.0 сая төгрөг
- Нийтлэг үйлчилгээний албанд тоног төхөөрөмж худалдан авах 21.3 сая төгрөг
- Улаан загалмайн хороонд микро автобус худалдан авах 45.0 сая төгрөг

- Энэрэл төвд ухаалаг самбар худалдан авах 18.9 сая төгрөг
- Эх дэлхийн цаг арга хэмжээ зохион байгуулах 5.0 сая төгрөг
- Баян наадмын зардал 610.0 сая төгрөг
- Эрдэнэт сангийн ажилтны үйл ажиллагааны зардал 14.1 сая төгрөг
- ГБХЗХГ-ын үйл ажиллагааны зардал 19.8 сая төгрөг тус тус байна.

1.7. Орхон аймгийн ТЭЗ-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 128,194.4 сая төгрөгийн 205 төсөл арга хэмжээ нь Алсын хараа-2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөртэй агуулгаараа 88.8% нийцэж байна.

1.8. Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх, эдийн засаг, дэд бүтэц болон төрийн бүтээмжийг сайжруулахад чиглэсэн 10 хүртэлх жилийн хугацаанд хэрэгжих дунд хугацааны зорилтот хөтөлбөр болох Шинэ сэргэлтийн бодлогыг Монгол улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолоор баталсан.

1.9. Тус хөтөлбөрийн хүрээнд Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрт 5 зорилтын хүрээнд 89 үйл ажиллагааг хэрэгжүүлэх бол Орхон аймгийн ТЭЗ-ийн төсвийн төсөлд зарим үйл ажиллагаа бүрэн тусгагдаагүй байна. Тухайлбал:

- Хот хөдөөгийн сэргэлт /Эдийн засгийн чөлөөт бүсийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан иргэд, аж ахуйн нэгжүүдийг цогц бодлогоор дэмжих замаар төвлөрлийг сааруулна/
- Аж үйлдвэрийн сэргэлт /Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэвшилтэт техник, технологи, инновацад тулгуурлан хөгжүүлж, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлнэ, Хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний нөөцтэй уялдуулан боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар хагас боловсруулсан бүтээгдэхүүний экспортын хувь хэмжээг бууруулан нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ/

1.10. Төсөл хөтөлбөрийн зардалд батлагдаж буй 11,667.4 сая төгрөгийн 185 төсөл арга хэмжээ нь хөрөнгийн шинж чанаргүй урсгал үйл ажиллагааны зардал учраас Алсын хараа-2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаатай уялдаж байгаа эсэхийг үнэлж дүгнэх боломжгүй байна.

1.11. Орхон аймгийн ИТХ-ын 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 02/01 тогтоолоор Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг 8 зорилтын хүрээнд 30 арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд хөрөнгө оруулалтын 128,194.4 сая төгрөгийн 205 төсөл арга хэмжээг нийцэж байгаа эсэхэд тулган баталгаажуулалт хийсэн.

Хүснэгт 4. Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан байдал. /сая.төгрөг/

№	Зорилтын нэр	ТАХ тоо	Зарцуулах мөнгөн дүн	Эзлэх хувийн жин
1	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	2	356.03	0.28%
2	Эрүүл бүтээлч хөгжих тэмүүлэлтэй эрдэнэт хүн	25	7,948.78	6.20%
3	Амьдралын чанар ба дундаж давхарга	32	7,622.62	5.95%
4	Эдийн засаг	2	99.01	0.08%
5	Тогтвортой засаглал-эрдэнэт хүн	14	6,317.63	4.93%
6	Ногоон-Эрдэнэт хот	9	3,194.34	2.49%
7	Аюулгүй амар тайван Эрдэнэт хот	7	858.11	0.67%
8	Тогтвортой хөгжил Эрдэнэт хот	86	94,681.15	73.86%
9	Тусгагдаагүй бусад	28	7,116.75	5.55%

<b>Нийт дүн</b>	<b>205</b>	<b>128,194.42</b>	<b>100%</b>
-----------------	------------	-------------------	-------------

1.12. Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлтэй 128,194.4 сая төгрөгийн 205 төсөл арга хэмжээнээс 121,077.7 сая төгрөгийн 177 төсөл арга хэмжээ нийцэж байгаа бол үлдсэн 7,116.8 сая төгрөгийн 28 төсөл арга хэмжээ нийцэхгүй байна. Үүнд:

- Эрдэнэт Ус ДТС ОНӨХК-ийн Захиргааны байр барих 605.1 сая төгрөг
- Хүнс хөдөө аж ахуйн агропарк сургалтын байр хашаа буулгах 67.6 сая төгрөг
- ХХҮГ-ын оффисын байрны дээврийн засварын ажил 30.1 сая төгрөг
- ХХҮГ-ын дэргэдэх Ахмадын сувиллыг "Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний сэргээн засалтын төв" болгон өргөжүүлэхтэй холбогдуулан их засвар хийх 220.8 сая төгрөг
- Нутгийн удирдлагын ордны 3 дугаар давхрын өрөөг хүндэтгэлийн танхим болгон засварлаж тохижуулах 186.9 сая төгрөг
- Эрдэнэ баг. Хэмнэл соёлын төвийн барилгын их засвар хийх 262.7 сая төгрөг
- Захиргааны 1 дүгээр байрны ариун цэврийн өрөөнүүдийн засвар хийх 116.0 сая төгрөг
- Дэнж багийн Элит I, II байрны гадна фасад, заадсыг засварлах 226.5 сая төгрөг
- Жаргалант сумын эмнэлгийн хажууд граж, моргийн барилга барих 194.6 сая төгрөг
- Согоот баг. Баян-Өндөр сумын 14-р сургуулийн дутуу баригдсан өргөтгөлийг буулгах 300.0 сая төгрөг
- Аймгийн ёслолын өргөөнд засвар хийх 100.0 сая төгрөг
- ОНӨГ-ын ажлын байрны засвар, тохижилт хийх /Зэст багийн байранд орох/ 61.7 сая төгрөг
- УЦУОШТ-д лабораторийн ширээ худалдан авах 6.8 сая төгрөг
- Хүндэт харуулын үйл ажиллагаанд шаардлагатай хивс худалдан авах 21.7 сая төгрөг
- Худалдан авах ажиллагааны газарт шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах 60.0 сая төгрөг
- Аялгуу соёлын төвд тоног төхөөрөмж худалдан авах 27.0 сая төгрөг
- Баянцагаан соёлын төвд тоног төхөөрөмж худалдан авах 20.8 сая төгрөг
- Хүүхдийн ордонд лед дэлгэц худалдан авах /4x7 хэмжээтэй/ 95.0 сая төгрөг
- Соёл урлагийн газарт тоног төхөөрөмж худалдан авах 44.8 сая төгрөг
- Хүүхэд залуучуудын театрт лед дэлгэц худалдан авах 95.0 сая төгрөг

1.13. Аймгийн ИТХ-ын 2023 оны 09 дүгээр сарын 14-ны өдрийн 16/03 дугаар тогтоолоор Орхон аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөг баталсан бөгөөд уг төлөвлөгөөнд 46 зорилтын хүрээнд 277 төсөл арга хэмжээг төлөвлөснийг төсвийн төсөлд тусгагдсан 139,861.8 сая төгрөгийн 390 төсөл арга хэмжээтэй тулган баталгаажуулсан.

1.14. Аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөтэй 129,243.9 сая төгрөгийн 311 төсөл арга хэмжээ буюу 92.4% нь нийцэж байна. Харин үлдсэн 10,617.9 сая төгрөгийн 79 төсөл арга хэмжээ буюу 7.6% нь нийцэхгүй хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна. /Хавсралт-1 харуулав/

**Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтын иргэдээс авсан саналд үндэслэсэн байна.**

1.15. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээний саналыг иргэдээс 2023 оны 3, 8 дугаар сард авч, аймгийн Засаг даргын 13 удаагийн уулзалт хэлэлцүүлгээр гарсан саналуудын баг тус бүрээр нэгтгэн, эрэмбэлж, хөрөнгө оруулалтын ТАХ-нд тусгасан байна.

1.16 Төсвийн төсөлд он дамжин хэрэгжиж буй Эрдэнэт Ус ДТС ОНӨХК-ийн Захиргааны байр барих 605.1 сая төгрөг, Уран эгшиг сургуулийн өргөтгөлийн барилга барих 1,297.1 сая төгрөг, "Эрдэнэтэд үйлдвэрлэв" барилга барих 2,000.0 сая төгрөг, Оюут багийн төрийн үйлчилгээний нэгдсэн төв барих 2,789.3 сая төгрөг, Дэнж багийн төрийн үйлчилгээний нэгдсэн төв барих 2,539.0 сая төгрөг, нийт 9,230.5 сая төгрөгийн 5 ТАХ-ний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, урсгал зардлын талаар үндэслэлтэй тооцоо судалгаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 29<sup>1</sup>.1<sup>1</sup>, 29<sup>1</sup>.2.4<sup>2</sup>-д заасантай нийцээгүй байна.

1.17. ТЕЗ нь Төсвийн тухай хуулийн 14.2.11<sup>3</sup>-д заасан төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, төсвийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх зорилгоор өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллагад 3-5 жилд нэг удаа чиг үүрэг, үр дүнгийн шинжилгээ хийж, үр дүнг Засгийн газарт танилцуулаагүй байна.

1.18. Төсөл хөтөлбөрийн зардлаас хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах төлөвлөгөөт ажлын зардалд 300.0 сая төгрөг төлөвлөсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.4<sup>4</sup>-д заасантай нийцэхгүй байна.

1.19. Тэмцээн уралдааны зардалд 253.0 сая төгрөг, дэмжлэг үзүүлэх зардалд 705.6 сая төгрөг, төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулах сурталчлан таниулах зардалд 1,230.9 сая төгрөг, урсгал үйл ажиллагааны зардалд 2,013.9 сая төгрөг, нөхөн олговрын зардалд 745.1 сая төгрөг, шагналын зардалд 180.0 сая төгрөг, дэд хөтөлбөр хэрэгжүүлэх зардалд 2,210.0 сая төгрөгийг тус тус зарцуулахаар төсөвлөсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.1<sup>5</sup>, 4.2.6<sup>6</sup>-д заасантай нийцэхгүй байна.

#### **ХОЁР СУМДЫН ОРЛОГЫГ БОДИТ ГҮЙЦЭТГЭЛД ҮНДЭСЛЭН НЭМЭГДҮҮЖ, ЗАРДЛЫГ ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД НИЙЦҮҮЛЭН ХЭМНЭХ БОЛОМЖ БАЙНА.**

**Төсвийн орлогыг тооцоо судалгаанд тулгуурлаж бодитой төлөвлөснөөр төсвийн орлого 309.0 сая төгрөгөөр нэмэгдэх боломжтой байна.**

2.1. Сангийн яамнаас Орхон аймгийн 2024 оны суврь орлогыг 250.945.9 сая төгрөгөөр, суврь зарлагыг 42,661.0 сая төгрөгөөр хянаж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд Орхон аймгаас улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 178,422.2 сая төгрөгөөр тусгасан байна.

<sup>1</sup> Төсвийн тухай хуулийн 29<sup>1</sup>.1-д "Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна",

<sup>2</sup> Төсвийн тухай хуулийн 29<sup>1</sup>.2.4-д "урсгал зардал гарах төслийн урсгал зардлыг тооцсон байх",

<sup>3</sup> Төсвийн тухай хуулийн 14.2.11-д "төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллагад 3-5 жил тутамд нэг удаа чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээ хийж, үр дүнг Засгийн газарт танилцуулах",

<sup>4</sup>Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.4-д "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх"

<sup>5</sup> Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.1-д "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах",

<sup>6</sup> Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.6-д "үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх",

2.2. Төсвийн хэлэлцүүлгийн явцад Улсын Их Хурал дээр Орхон аймгийн суурь зарлагыг 705.1 сая төгрөгөөр бууруулж, Төсвийн тухай хуулийн 56.2<sup>7</sup>-д заасны дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд Орхон аймгаас улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 179,620.9 сая төгрөгөөр баталсан байна.

2.3. Төсвийн тухай хуулийн 8.3.4<sup>8</sup>-д заасан Сангийн яамнаас ирүүлсэн төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамжийн дагуу Орхон аймгийн төсвийн төслийг боловсруулж хүргүүлсэн байна.

2.4. Дээрх удирдамжид өмнөх жилийн удирдамжаас өөрчлөгдсөн зүйл нь орон нутгийн төсвийн орлогын саналыг онлайнд суурилсан Fiscal-B системээр хүлээн авахаар тусгасан байна.

Хүснэгт 5. Орхон аймгийн 2024 оны суурь орлого, суурь зардал. /сая төгрөг/

Д/д	Үзүүлэлт	Суурь орлого	Суурь зардал	Тэнцэл	Орон нутгийн төсөвт үлдэх	Улсын төсөвт төвлөрүүлэх
		1	2	3=2-1	4=2*0.7	5=1-2-4
1	Сангийн яам хянасан төсөл	250,945.9	42,661.0	208,284.9	29,862.7	178,422.2
2	УИХ-аар баталсан	250,945.9	41,955.9	208,990.0	29,369.1	179,620.9

2.5 Орхон аймгийн 2024 оны төсвийн төсөлд Сангийн яамны хянасан татварын орлогыг 27,721.2 сая, татварын бус орлогыг 12,840.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж төлөвлөсөн байна.

Хүснэгт 6. Орхон аймгийн 2024 оны төсвийн орлого. /сая төгрөг/

Үзүүлэлт	Сангийн яам хянасан	Төсвийн төсөлд туссан	Өөрчлөлт
	1	2	3=2-1
<b>Татварын орлого</b>	<b>246,994.8</b>	<b>274,716.0</b>	<b>27,721.2</b>
<b>Аймгийн төсөв</b>	<b>154,955.5</b>	<b>155,580.0</b>	<b>624.5</b>
Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	153,000.0	153,000.0	0.0
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	1,100.0	1,300.0	200.0
Улсын тэмдэгтийн хураамж	505.5	580.0	74.5
Ус рашааны нөөц ашигласны төлбөр	350.0	700.0	350.0
<b>Сумын төсөв</b>	<b>92,039.3</b>	<b>119,136.0</b>	<b>27,096.7</b>
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	66,300.0	71,000.0	4,700.0
Үйл ажиллагааны орлого	471.0	471.0	0.0
Хөрөнгийн орлого	2,922.0	2,922.0	0.0
Хөрөнгө борлуулсны орлого	3,000.0	3,000.0	0.0
Шууд бус орлого	1,390.0	1,390.0	0.0
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-5,300.0	-5,400.0	-100.0
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	11,000.0	18,000.0	7,000.0
Бууны албан татвар	40.0	40.0	0.0
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	45.0	45.0	0.0

<sup>7</sup> Төсвийн тухай хуулийн 56.2.2-д “доод шатны төсвийн үндсэн тэнцлийн ашиг нь суурь зарлагаас их тохиолдолд суурь зарлагатай тэнцэх хэсгийн 60 хувийг 2017 оны төсвийн жилд, 40 хувийг 2018 оны төсвийн жилд, 60 хувийг 2019 оны төсвийн жилд, 70 хувийг 2020 оны төсвийн жилээс эхлэн тухайн шатны төсөвт үлдээж, үлдэх хэсгийг дээд шатны төсөвт төвлөрүүлнэ”,

<sup>8</sup>Төсвийн тухай хуулийн 8.3.4-д “санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газрын баталсан жилийн төсвийн хязгаарыг төсвийн удирдамжийн хамт жил бүрийн 7 дугаар сарын 5-ны дотор төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх”,

Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1,650.0	1,650.0	0.0
Үүнээс: Газрын төлбөр	10,503.3	26,000.0	15,496.7
Ойн нөөц ашигласны төлбөр	18.0	18.0	0.0
<b>Татварын бус орлого</b>	<b>1,951.1</b>	<b>14,792.0</b>	<b>12,840.9</b>
Торгуулийн орлого	1,450.0	1,450.0	0.0
Хүүгийн орлого	420.1	0.0	-420.1
Төсөвт байгууллагын өөрийн орлого <sup>9</sup>	81.0	32.0	-49.0
Түрээсийн орлого	0.0	766.9	766.9
Орон нутгийн өмчийн эд хөрөнгө борлуулсны орлого	0.0	12,543.1	12,543.1
<b>Тусламжийн орлого</b>	<b>35,099.6</b>	<b>200,786.5</b>	<b>51,010.0</b>
Хандив тусламжийн орлого	2,000.0	53,010.0	51,010.0
Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	33,099.6	33,099.6	0.0
<i>Баян-Өндөр сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого /сумын төсөв/</i>		114,676.9	
<b>Урьд оны шилжих үлдэгдэл</b>	<b>0.0</b>	<b>19,782.6</b>	<b>19,782.6</b>
Урьд оны шилжих үлдэгдлээс санхүүжих	0.0	16,259.1	16,259.1
Урьд оны шилжих үлдэгдлээс санхүүжих /ОНХС/	0.0	3,523.5	3,523.5
<b>Нийт дүн</b>	<b>284,045.5</b>	<b>390,941.2</b>	<b>106,895.7</b>

2.6. Баян-Өндөр сумын төсвийн орлогыг 119,136.0 сая төгрөгөөр хянаж, 114,676.9 сая төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна.

2.7. Тусламжийг орлогыг 51,010.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна. Энэ нь Орхон аймагт ажилласан Ерөнхий сайдын албан айлчлалын хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын дэмжлэгээр аймгийн авто замын сүлжээг шинэчлэн хучих ажлын зардал 50,000.0 сая төгрөг, Орхон аймаг болон Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ийн хамтын ажиллагааны гэрээний санхүүжилтийг 1,010.0 сая төгрөг нэмж төлөвлөсөнтэй холбоотой байна.

2.8. Татварын бус орлогод орон нутгийн өмчийн эд хөрөнгө борлуулсны орлого буюу Уртын гол багт баригдаж байгаа “Орлогод нийцсэн орон сууц” төслөөс урьд онд төвлөрүүлэхээр тусгасан орлогоос тасарсан дүн болох 12,543.1 сая төгрөг, орон нутгийн өмчийн түрээсийн орлого 766.9 сая төгрөгийг тус тус нэмж, Эрдэнэт хотын цэвэрлэх байгууламжийн өршөөлийн төсвийн санхүүжилтэй холбоотой 420.1 сая төгрөгийг хасаж тусгасан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь жилийн төсвийн төслөө Төсвийн тухай хуулийн 31.1.3<sup>10</sup>-д заасны дагуу тус хуулийн 4.1.8<sup>11</sup>-д заасан жилийн төсвийн хязгаарт багтаан төлөвлөх ёстой.

2.9. Жаргалант сумын төсвийн орлогыг 463.1 сая төгрөгөөр хянаж, тус суманд олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг 6,975.3 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

*Хүснэгт 7. Жаргалант сумын төсвийн орлогын судалгаа. /сая.төгрөг/*

Үзүүлэлт	2022 оны гүйцэтгэл	2023 оны төлөвлөгөө	2023.10 гүйцэтгэл	2024 оны төсвийн санал	Аймгийн төсөвт хянасан	Орлого нэмэгдүүлэх боломж
	1	2	3	4	5	6=4-5
Жаргалант сумын татварын орлого	497.9	1,164.2	914.2	764.2	463.1	301.1

<sup>9</sup> Сангийн яамны хянасан төсөвт байгууллагын өөрийн орлого нь 2,081.0 сая төгрөг бөгөөд үүнээс 2,000.0 сая төгрөг нь Орхон аймаг болон Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ийн хамтын ажиллагааны гэрээний санхүүжилтийг хянасан дүн болно. Энэхүү гэрээний санхүүжилтийг аймгийн төсөвт хандив, тусламжийн орлогод тусгасан байна.

<sup>10</sup> Төсвийн тухай хуулийн 31.1.3-д “жилийн төсвийн хязгаарт багтаасан байх”,

<sup>11</sup> Төсвийн тухай хуулийн 4.1.8-д “жилийн төсвийн хязгаар” гэж төсвийн тусгай шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсөв боловсруулахад баримтлах орлогын доод хэмжээ, зарлагын дээд хэмжээг”,

2.10. Дээрх хүснэгтээс харахад Жаргалант сумын татварын орлогыг 301.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.

2.11. Аймгийн хэмжээнд бэлэн бус торгуулийн системээр 2023 оны 10 сарын байдлаар давхардсан тоогоор 37,825 иргэнд 890.4 сая төгрөгийн торгууль ногдуулж, орон нутгийн төсөвт 27,112 иргэний 638.3 сая төгрөгийн орлого төвлөрчээ. Иймд тус оны 10,713 иргэний 252.1 сая төгрөг, өмнөх оноос төлөгдөөгүй 12,834 иргэний 518.1 сая төгрөг нийт 770.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, татварын бус орлогыг нэмэгдүүлэх боломжтой байна.

2.12. Улаанбаатар хотод нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2009 оны 04/27 дугаар тогтоолоор баталсан “Нийтийн эзэмшлийн зам талбайд тээврийн хэрэгслийн төлбөртэй зогсоол ажиллуулах журам”-ын дагуу аж ахуй нэгж, байгууллага, иргэнтэй гэрээ байгуулан төлбөртэй зогсоол ажиллуулж олсон орлогын 60 хувийг авто замын санд төвлөрүүлдэг байна.

2.13. Иргэд ихээр үйлчлүүлдэг, тухайн байршлынхаа замын түгжрэлд нөлөө үзүүлдэг Хангайн бүс худалдааны төв, Цах маркет, Хүлэг зах, Орхон молл, Сансар худалдааны төвийн авто машины зогсоолд ажиглалт, зураг авалт хийж үзэхэд төлбөртэй зогсоол ажиллуулах зохицуулалтыг хийвэл зөвхөн энэ байршлаас татварын бус орлогыг 356.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.

Хүснэгт 8. Нийтийн эзэмшлийн талбайд тээврийн хэрэгслийн төлбөртэй зогсоол ажиллуулах тооцоо. /сая.төгрөг/

№	Байгууллагын нэр	Зогсоолын тоо	Тухайн үед байрлаж байсан машины тоо	Дүүргэлтийг 80 хувиар тооцсон тоо	1 цаг = 1000 төгрөг, 8 цаг /өдөрт/	Сард	Жилд	Орон нутагт төвлөрүүлэх хувь - 60
1	Орхон молл	59	60	48	0.38	9.6	115.2	69.1
2	Сансар худалдааны төв	56	41	32.8	0.26	6.6	78.7	47.2
3	Хангай худалдааны зах	102	114	91.2	0.73	18.2	218.9	131.3
4	Цах маркет	40	64	51.2	0.41	10.2	122.9	73.7
5	Хүлэг зах	38	30	24.0	0.19	4.8	57.6	34.6
	<b>Дүн</b>	<b>295</b>	<b>309</b>	<b>247.2</b>	<b>2.0</b>	<b>49.4</b>	<b>593.3</b>	<b>356.0</b>

2.14. Баян-Өндөр сумын Засаг даргын тамгын газар нь өмнөх онд спорт заал түрээсэлж 8.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. Мөн Ёс заншлын өргөөг түрээслүүлж орлого төвлөрүүлэх боломж байна. Эдгээр орлогыг төсөвт төлөвлөж, 8.0 саяас дээш төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх боломжтой байна.

Хүснэгт 9. Баян-Өндөр сумын спорт заалны түрээсийн орлогын тооцоо. /сая.төгрөг/

Д/д	Үзүүлэлт	2021 оны орлого	2022 оны орлого	2023 оны ХБГ	2024 онд төлөвлөх боломжит дүн
		1	2	3	4
2	Баян-Өндөр сумын ЗДТГ	2.8	8.6	8.0	8.0

Төсвийн зарлагыг 3,463.9 сая төгрөгөөр бууруулах боломжтой хэдий ч тооцоолол, судалгаагүй төлөвлөсөн байна.

2.15. Аймгийн 2024 оны төсвийн төсөлд төсвийн нийт зарлага 390,941.2 сая төгрөг, үүнээс орон нутгийн суурь зарлага 36,904.1 сая, хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн зардлыг

135,865.0 сая, төрийн болон орон нутгийн өмчийн барилгын үйлчилгээ ашиглалтын зардал 7,936.5 сая, орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлэг 20,682.5 сая, Жаргалант сумд олгох санхүүгийн дэмжлэгийг 6,975.3 сая, улсын төсөвт төвлөрүүлэх орлого болон дамжуулан зээлийн эргэн төлөлтийг 182,577.8 сая төгрөг байхаар тооцжээ.

2.16. Аймгийн өмчлөлд бүртгэж хянах боломжгүй 6 ТАХ-г 303.9 сая төгрөгөөр худалдан авахаар төлөвлөсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3-т “Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно”, 13.3.2-т “хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ” гэж заасантай нийцэхгүй байна. Үүнд:

- Чөлөөт бөхийн холбоонд дэвжээ худалдан авах 40.0 сая төгрөг
- Эрдэнэт хотын түүх, дурсгалын ном гаргах 20.0 сая төгрөг
- Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж худалдан авах 100.0 сая төгрөг
- Уурхайчин баг. Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж худалдан авах 80.0 сая төгрөг
- Улаан загалмайн хороонд микро автобус худалдан авах 45.0 сая төгрөг
- Энэрэл төвд ухаалаг самбар худалдан авах 18.9 сая төгрөг

2.17. Төсөл, хөтөлбөрийн зардалд төсөвлөсөн цалин, хөлсний зардлаар тайлагнаж буй 21 ТАХ-ний 3,090.1 сая төгрөгөөр зардал бууруулах боломжтой байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3<sup>12</sup>, 13.3.2<sup>13</sup>-д заасантай нийцэхгүй байна.

*Хүснэгт 10. Төсөл, хөтөлбөрийн зардалд төсөвлөсөн цалин, хөлсний зардлын тооцоо. /сая.төгрөг/*

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	2024 онд санхүүжих дүн
1	Төрийн үйлчилгээний операторын үйл ажиллагаа, бичиг хэргийн зардал (E-mongolia төв)	50.0
2	Хүн ам, орон сууцны завсрын тооллогын бэлтгэлийг хангах, зохион байгуулах зардал	30.0
3	"Нийгмийн даатгалын төлөөлөгч"-дийн зардал	85.0
4	Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний сэргээн засалтын төвийн үйл ажиллагааны зардал	145.0
5	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон иргэдэд боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөрийн сэргээн засах үйлчилгээ үзүүлэх төвүүдэд дэмжлэг үзүүлэх зардал	382.6
6	Орон нутгийн циркийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зардал	25.0
7	Сайн үйлс төвийн үйл ажиллагааг дэмжих зардал	20.0
8	Түргэн тусламжийн үйл ажиллагааны зардал	385.0
9	Туслах сувилагч ажиллуулах зардал /10хүн/	50.0
10	Хувь хүний орлогын албан татварын хэсгийн урсгал зардал	176.2
11	Эрх зүйн хөтөч ухуулагчдын цалингийн зардал	68.1
12	Хүчирхийлэлд өртсөн иргэдийг түр хамгаалах байрны үйл ажиллагаа, иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлын зардал	45.0
13	Цагдаагийн газрын олон нийтийн цагдаагийн ажилтны цалин, НДШ-ийн зардал	459.0

<sup>12</sup> Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3-д “Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно”,

<sup>13</sup> Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3.2-д “хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ”,

14	Мэдээлэл лавлагаа хариуцсан туслах ажилтан болон төрийн архивын гэрээт ажилтны цалин, НДШ-ийн зардал	53.2
15	Иргэний бүртгэлийн болон хуулийн этгээдийн бүртгэлийн архивыг цахимжуулах ажлын зардал	29.7
16	"Эрдэнэт" цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргааны үйл ажиллагааны зардал	406.5
17	Аймгийн ИТХ-ын дэргэдэх иргэний зөвлөлийн үйл ажиллагааны зардал	45.0
18	Жаргалант сумын хүүхдийн автобусны санхүүжилт	57.5
19	Залуучуудын ордны цалин, үйл ажиллагааны зардал	413.5
20	Эрдэнэт шинжлэх ухаан технологийн паркийн дэргэдэх Бизнес хөгжлийн төвийн урсгал зардал	98.8
21	Цахим Эрдэнэт-1 төслийн нэгжийн үйл ажиллагааны зардал	65.0
<b>ДҮН</b>		<b>3,090.1</b>

**ГУРАВ. ТӨСВИЙН ТӨСӨЛД ШИНЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН ТАХ-НИЙ ЭДИЙН ЗАСГИЙН ҮР АШИГ, НИЙГМИЙН АЧ ХОЛБОГДЛЫН БОЛОН АШИГЛАЛТЫН ЗАРДЛЫН ТООЦООЛЛЫГ ХИЙХГҮЙ ТӨЛӨВЛӨСӨӨР БАЙНА.**

Төсвийн төсөлд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний барилга байгууламжийн ангилалд төсөвлөлтийн шаардлага хангаагүй 11 төсөл, арга хэмжээг тусгасан байна.


3.1. Аймгийн 2024 оны төсвийн төсөлд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 171,436.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 377 төсөл, арга хэмжээг 135,865.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгасан байна.

Хүснэгт 11. Төсөл, арга хэмжээний ерөнхий мэдээлэл. /сая.төгрөг/

Ангилал	Шилжих ТАХ			Шинэ ТАХ			Нийт ТАХ		
	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Барилга, байгууламж	36	54,720.9	19,659.2	93	84,567.6	87,422.6	129	142,288.6	107,081.8
Их засвар	8	356.3	224.3				8	356.3	224.3
Тоног төхөөрөмж	4	4,445.0	4,445.0	39	9,787.1	9,787.1	43	14,232.1	14,232.1
Төсөл, арга хэмжээ				190	13,525.9	13,525.9	190	13,525.9	13,525.9
Зөвлөх үйлчилгээ	7	1,033.3	800.9				7	1,033.3	800.9
<b>Нийт</b>	<b>55</b>	<b>60,555.6</b>	<b>25,129.3</b>	<b>322</b>	<b>107,880.7</b>	<b>110,735.7</b>	<b>377</b>	<b>171,436.2</b>	<b>135,865.0</b>

3.2. Аймгийн ИТХ-ын 2023 оны 09 дүгээр сарын 16/03 дугаар тогтоолоор баталсан "Аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө"-д нийт 181 төсөл, хөтөлбөр, арга хэмжээг 272,666.8 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр тусгасан байна.

График 1. Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал. /хувиар/



3.3. Нийт эх үүсвэрийн 17.8 хувь буюу 46,351.0 сая төгрөгийн 121 төсөл, хөтөлбөр, арга хэмжээг орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэхээр тусгажээ.

3.4. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.4-т заасны дагуу Орхон аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээг аймгийн төсвөөс 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний жагсаалтад хэрхэн туссаныг авч үзэхэд 56 төсөл, арга хэмжээ төсвийн төсөлд тусгаагүй байна.

3.5. Аймгийн 2024 оны төсвийн төсөлд төсөвлөлтийн шаардлага бүрэн хангаагүй хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээг тусгасан байна.

3.6. Аймгийн төсвөөс 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээгээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн шинээр эхлэх 322 ТАХ-ээс 93 нь Барилга байгууламжийн ангилалд хамаарч байна. Тус ангилалд хамааруулсан ТАХ-г авч үзвэл 11 ТАХ нь барилга байгууламж, 82 нь их засварын ажилд хамаарахаар байна. Энэ нь Барилгын тухай хуулийн 4.1.1<sup>14</sup>-д заасантай нийцэхгүй байна.

3.7. Мөн зураг, төсөвтэй хэрэгжих 93 ТАХ-ээс 88.1 хувь буюу 82 ТАХ нь зураг, төсөвтэй, 11.9 хувь буюу 11 ТАХ иж бүрэн бус зураг, төсөл нь хийгдэж байна. Үүнээс 5 ТАХ-г зураг, төслийн төсөвт өртгөөс бууруулж, 3 ТАХ-ний төсөвт өртгийг нэмэгдүүлж төлөвлөсөн байна. Эндээс үзвэл ТАХ нь төлөвлөсөн хугацаандаа хэрэгжихгүй байх, төсөвт өртөг нэмэгдэх, үргүй зардал гаргах эрсдэл үүсгэхээр байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29<sup>1</sup>.2.2<sup>15</sup>, ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.2.2-д “Барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх” гэж заасантай нийцээгүй, эдгээр ТАХ-г төсвийн жил эхлэхээс өмнө холбогдох шаардлагад нийцүүлэх шаардлагатай байна.

3.8. Нэг маягийн зураг төсөлтэй төсөл, арга хэмжээнд холболтын зураг төслийн төсөв нэмэгдэж, төсөвт өртөг өсөж, цаг хугацаандаа хэрэгжихгүй байх эрсдэлийг үүсгэхээр байна. Түнд: Дэнж багийн төрийн үйлчилгээний нэгдсэн төв барих, Оюут багийн төрийн үйлчилгээний нэгдсэн төв барих.

3.9. Төсвийн тухай хуулийн 29<sup>1</sup>.1-д “Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь ... эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна” гэж заасан хэдий ч 2024 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-ний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлын тооцооллыг хийгээгүй байна.

3.10. Мөн барилга байгууламж ангиллын ТАХ-ний үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой зардлын тооцооллыг хийгээгүй, төсөвт нөлөөлөх ачааллын дүгнэлтийг огт гаргаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29.2<sup>16</sup>, ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.2.2<sup>17</sup>-ыг тус тус зөрчсөн байна.

<sup>14</sup> Барилгын тухай хуулийн 4.1.1-д “барилга байгууламж” гэж орон сууц, иргэн, үйлдвэр, эрчим хүч, харилцаа холбоо, ус, нефтийн барилга, ус суваг, далан хаалт зэрэг байгууламж түүний инженерийн шугам сүлжээг”,

<sup>15</sup> Төсвийн тухай хуулийн 29<sup>1</sup>.2.2-д “барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх”,

<sup>16</sup> Төсвийн тухай хуулийн 29.2-д “Хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байна”,

<sup>17</sup> Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.2.2-д “барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх”,

3.11. Аймгийн 2024 оны төсвийн төсөлд шинээр хэрэгжүүлэхээр тусгасан 322 ТАХ-ний тухайн жилийн санхүүжих дүнг Төсвийн тухайн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5<sup>18</sup>-д заасан шаардлагыг хангасан байна.

3.12. Аймгийн төсвөөс 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээгээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн шинээр эхлэх ТАХ-ээс 39 нь тоног төхөөрөмж ангилалд хамаарч байна. Үүнээс 20 байгууллага үнийн судалгаа, албан тоот бичиг ирүүлсэн байна.

3.13. Төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-д тавих шаардлага болох ашиглалтын норм, элэгдлийн байдал, мэргэжлийн байгууллагын дүгнэлт, төсөв, холбогдох баримт бичгийн бүрдэлт хангаагүй ТАХ-г төлөвлөсөн байна. Тухайлбал нэн шаардлагатай бус Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцээгүй 2 ТАХ-д 97.0 сая төгрөг /Аялгуу соёлын төвд тоног төхөөрөмж худалдан авах – 27.0 сая төгрөг, Хүчний гурван төрөлт фитнесийн холбоонд тоног төхөөрөмж худалдан авах – 60.0 сая төгрөг, Орон нутгийн өмчит хувьцаат компани өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр худалдах авах боломжтой 1 ТАХ-д 1,260.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөжээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.3.4<sup>19</sup>-дэх заалттай нийцэхгүй байна.

3.14. Аймгийн төсвөөс 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээгээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн шинээр эхлэх 322 ТАХ-ээс 190 нь төсөл, хөтөлбөр ангилалд хамаарч байна. Үүнээс 20 төсөл, хөтөлбөр нь Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан, дэд хөтөлбөрийн дагуу хэрэгжиж, бусад 159 арга хэмжээ нь ихэвчлэн урсгал зардал, дэмжлэгийн зардал гэж үзэхээр байна.

3.15. Эдгээр төсөл, хөтөлбөрийн зардлын эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, урсгал зардлын тооцоолол зэргийг нягталж, эрэмбэлдэггүй, хөгжлийн бодлоготой хэрхэн уялдсан эсэхийг тодорхойлохгүйгээр төсвийн төсөлд тусгасаар байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 4.1.16<sup>20</sup>, 4.1.17<sup>21</sup>-д заасантай нийцэхгүй байна.

**Төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-г эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, урсгал зардлын тооцоолол, судалгаагүй төлөвлөж байна.**

3.16. Аймгийн төсвөөс 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээгээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн шинээр эхлэх ТАХ-үүд нь эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, урсгал зардлын тооцоололгүй, хөгжлийн бодлогын уялдааг хангасан эсэхийг тодорхойлохгүйгээр төсвийн төсөлд тусгасаар байна.

3.17. Өмнөх онд баталж, хэрэгжсэн ТАХ-г дахин төлөвлөж, үр нөлөөг тооцоогүй байна: Үүнд:

- "Тэгш боломж төсөл"-ийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулиудад тоног төхөөрөмж худалдан авах
- "Эрүүл хүүхэд төсөл"-ийн хүрээнд ЕБС-д эрүүл мэндийн жишиг кабинет байгуулах.
- "Хүүхэд хөгжил төсөл"-ийн хүрээнд ЕБС-дад тоног төхөөрөмж худалдан авах
- Аялгуу соёлын төвд тоног төхөөрөмж худалдан авах

<sup>18</sup> Төсвийн тухай хуулийн 29.5-д “Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож ...”,

<sup>19</sup> Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.3.4-д “тухайн барилга байгууламжийн ашиглалт, норм, хугацаа, элэгдлийн байдал, мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, засварын хөрөнгийн төсөв, холбогдох баримт бичигт үндэслэсэн байх”,

<sup>20</sup> Төсвийн тухай хуулийн 4.1.16-д “хөтөлбөр - гэж төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохгүй өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээг”.

<sup>21</sup> Төсвийн тухай хуулийн 4.1.17-д “арга хэмжээ - гэж хөтөлбөрийн бүрэлдэхүүнд багтах, тоо хэмжээ, цаг хугацаа, чанарын шалгуур үзүүлэлтээр тодорхойлогдох ажил, үйлчилгээг”

- Шинээр ашиглалтад орох "Номын өргөө"-нд тоног төхөөрөмж худалдан авах
- Нийтлэг үйлчилгээний албанд тоног төхөөрөмж худалдан авах

3.18. Төсөл, хөтөлбөрийн зардалд төлөвлөсөн 190 ТАХ-ээс 148 нь үргэлжлэн хэрэгжиж байгаа хэдий ч үр дүнг нь тооцоогүй, үнэлж дүгнээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14.2.2<sup>22</sup>, 14.2.3<sup>23</sup>, 4.1.16, 4.1.17-д заасантай нийцэхгүй байна.

### **ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ 75.0 ХУВЬТАЙ БАЙНА.**

1. Төрийн аудитын байгууллага Төрийн аудитын тухай хууль, Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу өмнөх аудитын тайланд дурдсан асуудал, зөвлөмжийн мөрөөр хариуцагч талын авч хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлд хяналт үнэлгээ хийх үүрэгтэй.

2. Энэ нь өмнөх аудитын үр нөлөөг батжуулж, дараагийн аудитын чанар, үр нөлөөг сайжруулах нөхцөл болох бөгөөд аудитын үнэ цэнийг нэмэгдүүлэх, зорилготой хэрэглэгчийг өмнө хийсэн аудитын тайлан болон тухайн үеийн нөхцөл байдлыг эргэн санах, дүгнэх боломж олгодог чухал ач холбогдолтой аудитын нэг үе шат юм.

3. "Орлогод нийцсэн орон сууц" төслийн орон сууцыг худалдан борлуулж, орлого төвлөрүүлэх журам, аргачлал хууль тогтоомжид нийцүүлэн баталж, мөрдөн ажиллаж эхэлсэн байна.

4. Төсвийн эрх захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, үр дүнгийн гүйцэтгэлийг харгалзан, өөрчлөлтийг тусган батлахаар төлөвлөж, хэрэгжилтийг үнэлсэн байна.

5. Төсвийн хөрөнгөөр боловсруулсан барилга, байгууламжийн зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэлийн мэдээллийн нэгдсэн цахим сан бүрдүүлэн, төсвийн төлөвлөлтөд ил тод, нээлттэй ашиглах боломжийг хангуулахаар ажилласан байна.

6. Аймгийн 2023 оны төсвийн төсөлд дүгнэлт өгсөн аудитаар аймгийн ИТХ болон Засаг даргад 4 зөвлөмж хүргүүлснээс 1 зөвлөмж хэрэгжих шатанд, 3 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, гүйцэтгэл 75.0 хувьтай байна.

<sup>22</sup> Төсвийн тухай хуулийн 14.2.2-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох"

<sup>23</sup> Төсвийн тухай хуулийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"

## **ДҮГНЭЛТ:**

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Орхон аймгийн 2024 оны төсвийн төсөл нь Монгол Улсын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаатай 97.6%, дунд хугацааны хөгжлийн бодлого буюу аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлтэй 94.5%, богино хугацааны хөгжлийн бодлого болох аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөтэй 92.4% тус тус нийцэж байна
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтыг иргэдээс авсан саналд үндэслэсэн байна.
- Төсвийн орлогыг тооцоо судалгаанд тулгуурлаж бодитой төлөвлөснөөр төсвийн орлого 309.0 сая төгрөгөөр нэмэгдэх боломжтой байна.
- Төсвийн зарлагыг 3,463.9 сая төгрөгөөр бууруулах боломжтой, тооцоолол, судалгаагүй төлөвлөсөн байна.
- Төсвийн төсөлд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний барилга байгууламжийн ангилалд төсөвлөлтийн шаардлага хангаагүй 11 төсөл, арга хэмжээг тусгасан байна.
- Төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-г эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, урсгал зардлын тооцоолол, судалгаагүй төлөвлөж байна.

## **ЗӨВЛӨМЖ:**

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

### **Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд:**

- Төсвийн тухай хуулийн 29, 29<sup>1</sup> дүгээр зүйл, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д тус тус заасан төсөвлөлтийн шаардлагыг хангасан төсөл, арга хэмжээг баталж байх.

### **Аймгийн Засаг даргад:**

- Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний зорилго, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийн тухайн жилийн төсөвт төсөвлөлтийн шаардлага хангасан эсэхийг тодорхойлж тусгаж байх.
- Төсвийн орлого нэмэгдүүлэх болон төсвийн зардал, төсөл арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тодорхойлж, тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөх

## ХАВСРАЛТ:

## Хавсралт №1

## Орхон аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдаагүй төсөл арга хэмжээ.

/сая.төгрөг/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Мөнгөн дүн
1	Эрдэнэт Ус ДТС ОНӨХК-ийн Захиргааны байр барих	605.09
2	Хүнс хөдөө аж ахуйн агропарк сургалтын байр хашаа буулгах	67.64
3	Зураг төсвийн зардал	478.37
4	Болзошгүй аваарын зардал	2,000.00
5	Зөвлөх үйлчилгээний зардал	1,000.00
6	ХХҮГ-ын оффисын байрны дээврийн засварын ажил	30.10
7	Эрчим хүчний хэмнэлттэй Хайбрид амины орон сууц барих	54.94
8	Нутгийн удирдлагын ордны 3 дугаар давхрын өрөөг хүндэтгэлийн танхим болгон засварлаж тохижуулах	186.90
9	Нутгийн удирдлагын ордны барилгад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан шат угсрах, довжоо хийх	164.44
10	Баян-Өндөр сумын 9 давхар орон сууцнуудын цахилгаан шат засварлах /4, 5-р хороолол/	385.00
11	Захиргааны 1 дүгээр байрны ариун цэврийн өрөөнүүдийн засвар хийх	116.00
12	Дэнж багийн Элит I, II байрны гадна фасад, заадсыг засварлах	226.48
13	Согоот баг.Баян-Өндөр сумын 14-р сургуулийн дутуу баригдсан өргөтгөлийг буулгах	300.00
14	Аймгийн ёслолын өргөөнд засвар хийх	100.00
15	ОНӨГ-ын ажлын байрны засвар, тохижилт хийх /Зэст багийн байранд орох/	61.74
16	Хүндэт харуулын үйл ажиллагаанд шаардлагатай хивс худалдан авах	21.66
17	Худалдан авах ажиллагааны газарт шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	60.00
18	Хүн ам, орон сууцны завсрын тооллогын бэлтгэл хангах тоног төхөөрөмж худалдан авах	13.16
19	Нийтлэг үйлчилгээний албанд тоног төхөөрөмж худалдан авах	21.34
20	Аймгийн Тагнуулын газарт ухаалаг самбар болон холбогдох тоног төхөөрөмж худалдан авах	200.00
21	Шүүхийн Тамгын газарт компьютер, тоног төхөөрөмж худалдан авах	100.00
22	Улаан загалмайн хороонд микро автобус худалдан авах	45.00
23	Энэрэл төвд ухаалаг самбар худалдан авар	18.90
24	Баян-Өндөр уул болон 7 бурхан одны тахилгын зардал	40.00
25	Аймгийн Засаг даргын нэрэмжит шагналын зардал /Төрийн болон орон нутгийн шагнал гардуулах, зохион байгуулах үйл ажиллаганы зардал/	180.00
26	Нутгийн удирдлагын ордоны угтах үйлчилгээний зардал	30.00
27	Засгийн газрын Хэрэг Эрхлэх газарт аймгийн Засаг даргын Тамгын газрын жилийн үйл ажиллагааны тайланг хүргэж өгөх зардал	10.00
28	Орхон аймгийн хэмжээнд хэрэгжиж буй бодлогын баримт бичгийн эмхэтгэл гаргах зардал	18.00
29	Хүн ам, орон сууцны завсрын тооллогын бэлтгэлийг хангах, зохион байгуулах зардал	30.00
30	Статистикийн мэдээний хамралтыг нэмэгдүүлэх, мэдээллийн чанарыг сайжруулах, хэрэглээг нэмэгдүүлэх ажлын зардал	15.00
31	Жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллогын зардал	26.14
32	"Нийгмийн даатгалын төлөөлөгч"-дийн зардал	85.00

33	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зардал	15.00
34	Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт хорооны үйл ажиллагааны зардал	10.00
35	Нийгмийн халамжийн зөвлөлийн шийдвэр хэрэгжүүлэх зардал	35.00
36	Тэмдэглэлт өдрүүдийг зохион байгуулах үйл ажиллагааны зардал /Эх үрсийн баяр, Шинэ он угтах арга хэмжээ, Эрдэнэт хотын өдөр, Улс тунхагласны баяр/	80.00
37	"Эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх зардал	35.00
38	Сайн үйлс төвийн үйл ажиллагааг дэмжих зардал	20.00
39	Томуу,томуу төст өвчний дэгдэлтийн үед зорилтот бүлгийн хүүхдүүдийг амин дэмжүүлэх, нийтийг хамарсан халдварын дэгдэлт гарсан үед ӨЭМТ-ийг илүү цагаар ажиллуулсан нэмэгдэл хөлсийг тооцож олгох зардал	20.00
40	Улаан загалмайн хороонд олгох дэмжлэгийн зардал	50.00
41	"Эрүүл Эрдэнэт хүн" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зардал	100.00
42	Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох зардал	10.00
43	Булган аймагтай хамтран ажиллах төлөвлөгөө батлах, хамтын ажиллагааны зардал	120.00
44	Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааг иргэдэд тайлагнах, сурталчлах зардал	15.00
45	Стандарт, хэмжил зүйн хэлтсийн Үр, хорио цээрийн лабораторийн үйл ажиллагааны зардал	46.00
46	Барилгын салбарын инженер, техникийн ажилтнуудын мэргэшүүлэх сургалт зохион байгуулах зардал	5.00
47	Гадаад, дотоодын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зардал	30.00
48	Төрийн зарим байгууллагуудын (Хот тохижуулах газар, Цагдаагийн газар, БОЭТ) шатахуун, GPS, хяналтын зардал	25.00
49	Аймгийн хэмжээнд нэршил олгогдоогүй барилга, орон сууц, гудамж талбайд нэршил олгох үйл ажиллагааны зардал	5.00
50	Шилэн дансны тухай хууль тогтоомжийн үйлчлэлд хамаарах төрийн байгууллага болон хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ хэрэгжүүлэгч ААНБ-н Шилэн дансны хэрэгжилтийг сайжруулах, хуулийг сурталчилах ажлыг зохион байгуулах зардал	15.87
51	Мэргэжлийн байгууллагатай хамтран хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах зардал	20.00
52	Аймгийн 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөллийг бэлтгэж, хүргүүлэх зардал	10.00
53	"Монгол цэргийн өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх, хүүхэд залуучуудад эх оронч төлөвшлийг олгох олон талт арга хэмжээ зохион байгуулах зардал	30.00
54	Шүүхийн зардал	5.00
55	Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны зардал	10.00
56	Терроризмтой тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөлийн 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардал	20.00
57	Улсын дээд шүүхийн шийдвэрээр "Эрдэнэт ус ДТС" ОНӨХК-ийн Булган аймгийн татварын хэлтэст төлөх татварын өрийг барагдуулах зардал	199.00
58	Шүүхийн шийдвэрийн дагуу "Мөнгөн хөндий" ХХК-д олгох мөнгөн төлбөр	100.00
59	Улсын заан цолтнуудад хүндэтгэл үзүүлэх үндэсний бөхийн барилдааны зардал	30.00
60	Орхон аймагт цэнгээнт бүжгийн урлаг үүсэж хөгжсөний 30 жилийн ойн хүрээнд "Эрдэнэтийн бүжгийн хөгжил – 30 жил" соёл урлагийн цогц арга хэмжээний зардал	30.00
61	"Эрдэнэт" цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргааны үйл ажиллагааны зардал	406.48
62	Аймгийн ИТХ-ын дэргэдэх иргэний зөвлөлийн үйл ажиллагааны зардал	45.00
63	Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах төлөвлөгөөт ажлын зардал	250.00

64	Орон нутгийн бодлого шийдвэрийг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах зардал	40.00
65	Олон нийтийн дэд зөвлөлийн үйл ажиллагааны зардал	8.10
66	Залуучуудын ордны цалин, үйл ажиллагааны зардал	413.52
67	"Их шүтээн цогцолбор" ОНӨҮГ-ын үйл ажиллагааны зардал	30.00
68	Эрдэнэт спорт амралтын хүрээлэнгийн үйл ажиллагааны зардал /харуул, гэрэл цахилгаан/	45.66
69	Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх экспедицийн зардал	10.00
70	Иргэдтэй уулзах уулзалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний зардал	150.00
71	Дэнж баг, Зүүн дэнжид дулааны шугам татах газар шорооны ухалтын ажлын явцад эд хөрөнгөөр хохирсон иргэн Гантөрд нөхөн олговор олгох зардал	4.84
72	Гэр бүлийн ордоны сэтгэл зүйн төвийн үйл ажиллагааны зардал	20.00
73	Америк соёл мэдээллийн төвийн цалин, НДШ ийн зардал	85.00
74	Баяр наадмын зардал	610.00
75	Цэцэрлэгт хүрээлэнгийн хөрөнгө оруулалтын ажлын нэмэлт санхүүжилт	8.74
76	"Цэцэрлэгт хүрээлэн"-ийн хөрөнгө оруулалтын ажлын нэмэлт санхүүжилт	502.92
77	Эрдэнэт сангийн ажилтны үйл ажиллагааны зардал	14.09
78	ГБХЗХГ-ын үйл ажиллагааны зардал	19.80
79	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Стандарт хэмжилзүйн хэлтсийн лабораторын засварлах	172.00
	<b>Нийт дүн</b>	<b>10,617.91</b>